



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Бууцагаан сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2019/166/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор сум 2019 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576

Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 88089024

Цахим хаяг:

tsetsegmaadam@audit.gov.mn

Аудитор:

Г.Ганчимэг

Утас: 88268424

Цахим хаяг: ganaa_7133@yahoo.com

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	8
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	9
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11	Шилэн дансны мэдээлэл	11
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	11
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	11
3.	Менежментийн захидал	10
4.	Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	13
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	13
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	14
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	18
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	19

Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Г БУУЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Д.ЛХАГВАДОРЖ ТАНАА

2019.02.25 № 2/00
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем

C:\Users\Dell\Downloads\Гэрчилгээ (1).docx

2519166

болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

Тайлант онд Хөрөнгө оруулалтын зардлаар тендер зарлаагүй автомашин худалдан авах гэрээг 15,0 сая төгрөгөөр байгуулсан, хөрөнгө худалдан авахдаа нэг төрлийн арга хэмжээг хэсэгчилж гэрээ байгуулж худалдан авалт хийсэн, хөрөнгө оруулалтын зардлыг урсгал зардалд зарцуулсан, гүйцэтгэсэн горим сорилын дүнд илэрсэн алдаа, зөрчлийн дүн нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшингээс 56,9 сая төгрөгөөр давсан зэрэг зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.5, Засгийн газрын 2013 оны “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 68 дугаар тогтоол, Төсвийн тухай хуулийн 16.5.5. дэх заалтууд зөрчсөн бөгөөд “Эрх ба үүргийн”, “Үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

C:\Users\Dell\Downloads\Гэрчилгээ (1).docx

.АУДИТЫН ТАЙЛАН

2.1 Оршил

Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын дарга Д.Лхагвадорж-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 23-наас 2019 оны 02 дугаар сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Г.Ганчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019 оны 1 дүгээр сарын 25-ний өдрийн 2/259 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго: Бууцагаан сумын ЗДТГ нь Эх нутаг, уул усаа шүтэн төрийн хуулиа дээдэлсэн эрүүл, оюунлаг, бүтээлч, чинээлэг, иргэнтэй, байгаль орчны тэнцвэрт байдлыг хангахуйц дэд бүтэц, жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ, аялал жуучлал, эрсдэлгүй эдийн засагтай, “БАЯНМАНДАЛ” бүс нутгийнхаа хөгжлийн хандлагыг тодорхойлсон, улсын жишиг сум болно. гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

Үүнд:

- Төр эдийн засаг нийгмийн бодлогыг удирдлагын үйл ажиллагаа Засаг даргын дэргэдэх дотоод аудитын хорооны хурлаар хяналт шалгалтын үр дүнг баталгаажуулж хэлэлцүүлэх
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт, шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах, Хурал, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Зөрчлийн тухай хууль
- Захиргааны ерөнхий хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг

алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд 41 буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн "Acolous" программ хангамж ашигладаг байна.

Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд "Дунд" гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 7 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь аккрузаль сууриар бэлтгэгдсэн санхүүгийн тайлангийн хувьд дээрх үзүүлэлтийг суурь болгож авах нь зүйтэй гэж үзсэнтэй холбоотой юм.

Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1250.9 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 25.0 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь эрсдлийн үнэлгээ дунд байгаатай холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын төвшинг В201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын төвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 7 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилгүй, 3 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 1 асуудалд аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	63135.7	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	67.0	
	Дүн	2	63202.7	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Аудитын явцад "Өлзийт богд хайрхан" ХХК-тай бичгийн ширээ, тоног төхөөрөмж худалдан авах гэрээг 18889.6 төгрөгөөр байгуулж хөрөнгийг хүлээж аваагүй байхад хөрөнгийг орлогод авсан зөрчил илэрсэн.
Шийдвэрлэсэн: Санхүүгийн тайланд залруулга хийсэн.
2. Л.Болдбаатарын цалинг 291.6 мянган төгрөгөөр дутуу мэдээлж 67.0 төгрөгийн шимтгэлийг төлөөгүй байна.
3. Энэ нь Үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нийгмийн даатгалын тухай хуулийг зөрчсөн байна.
Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан эсэхэд тавих хяналт хэрхэн хэрэгжиж байгаад дараагийн аудитаар анхаарал хандуулах шаардлагатай.

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 346.3 сая төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 342.2 сая төгрөг буюу 98,8% -н гүйцэтгэлтэй байгаа нь 1026.2 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудит”-аар Шилэн дансны хуулийн 6.1-д заасан мэдээллийн өөрт хамаарах 25 мэдээллээс мэдээлээгүй 4, хугацаа хоцорч мэдээлсэн 1, тухай бүр байршуулах хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг бүрэн байршуулаагүй, нэмэлт санхүүжилтийн 65,0 сая төгрөгийн санхүүжилт, 45,0 сая төгрөгийн зарлагын гүйлгээг мэдээлээгүй байна.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар өмнөх зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг. Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг үзүүлэв. Үүнд:

3.1. Өмнөх аудит болон зөвлөмжийн биелэлт, үр дүн

3.1.1. Илрүүлэлт

Сургуулийн хичээлийн байр, спорт заалны халаалтын системийг шинэчлэх засварын ажлын магадалшгүй ажил, хяналтын зардлын 2275.0 мянган төгрөг, Байгаль орчны барьцааны төлбөрөөс 949.3 мянган төгрөгийг нийгмийн даатгалын шимтгэл, халаалтын зардалд зөвшөөрөлгүй зарцуулсан.

Энэ нь Эрх ба үүрэг, Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийн хангахгүй бөгөөд Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1,2,3,4- заалтуудыг зөрчсөн.

3.1.2. Эрсдэл

Тайлант хугацаанд бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламжийг зориулалт бусаар зарцуулах

3.1.3. Өгсөн зөвлөмж

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, өөрийн орлогын төлөвлөгөөг бодиттой төлөвлөх, Төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллах.

3.1.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар

Хэрэгжүүлж ажиллана.

3.2 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

3.2.1 Илрүүлэлт:

Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас 4.9 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан, 45.0 сая төгрөгийн анхан шатны баримтгүй гүйлгээ хийсэн, "Буянт богдын хишиг" хадгаламж зээлийн хоршоотой тендер зарлаагүй 15.0 сая төгрөгөөр гэрээ байгуулж 10.0 сая төгрөгийг олгосон байна.

Энэ нь Үнэн зөв байдал батламж мэдэгдэл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа , ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.1.2 дэх заалтыг тус тус зөрчсөн.

3.2.2 Эрсдэл:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах, төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрч байна. Цаашид анхаарч ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2019.05.20-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудит хийсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

			/Төгрөгөөр/
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>74,788,985.00</u>	<u>102,578,358.00</u>
33	АВЛАГА	00.00	28,928,900.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	39,300.00
335	Бусад авлага	00.00	28,889,600.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	28,889,600.00
35	БАРАА МАТЕРИАЛ	74,788,985.00	73,649,458.00
351	Түүхий эд материал	18,608,000.00	18,608,000.00
35110	Тусгай зориулалттай материал	18,608,000.00	18,608,000.00
354	Хангамжийн материал	39,970,985.00	38,831,458.00
35410	Бичиг хэргийн материал	2,893,838.00	2,915,838.00
35430	Сэлбэг хэрэгсэл	8,000,032.00	00.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	300,000.00
35450	Барилгын засварын материал	747,000.00	747,000.00
35470	Бусад хангамжийн материал	28,330,115.00	34,868,620.00
35600	Мал амьтад	16,210,000.00	16,210,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,640,540,998.89</u>	<u>3,322,658,749.35</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,640,540,998.89	3,322,658,749.35

Бууцагаан сумын ЗДТГ 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

392	Биет хөрөнгө	3,633,690,040.66	3,299,940,603.65
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,158,991,077.00	4,478,122,976.90
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,198,636,120.62	-
39203	Авто-тээврийн хэрэгсэл	217,025,700.00	260,920,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-100,967,139.52	-92,567,139.52
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	804,256,765.00	178,634,397.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-284,069,950.94	-120,219,597.69
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	80,689,045.00	89,662,111.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-50,599,335.26	-52,583,729.89
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	7,000,000.00	7,000,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	00.00	36,790,020.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-31,274,832.74
393	Биет бус хөрөнгө	6,850,958.23	22,718,145.70
39301	Програм хангамж	14,563,000.00	14,563,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-7,712,041.77	-9,844,854.30
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	18,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3,715,329,983.89</u>	<u>3,425,237,107.35</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>20,336,420.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	20,336,420.00
413	Өглөг	00.00	20,336,420.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	36,420.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	20,300,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>3,715,329,983.89</u>	<u>3,404,900,687.35</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	3,715,329,983.89	3,404,900,687.35
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	502,400,904.00	520,400,904.00
51101	Өмч: - төрийн	502,400,904.00	520,400,904.00
512	Хуримтлагдсан үр дүн	3,102,239,823.89	2,433,553,596.07
51210	Өмнөх үеийн үр дүн	3,102,239,823.89	3,114,508,131.89
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-680,954,535.82
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	110,689,256.00	450,946,187.28
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>3,715,329,983.89</u>	<u>3,425,237,107.35</u>

1.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	485,431,466.00	569,947,149.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	64,963,445.00	104,679,349.00
120	Нийтлэг татварын бус орлого	64,963,445.00	104,679,349.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	64,963,445.00	104,679,349.00

Бууцагаан сумын ЗДТГ 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,825,413.00	21,675,930.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	48,138,032.00	83,003,419.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	420,468,021.00	465,267,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	45,683,485.00	133,856,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	45,683,485.00	133,856,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	302,604,900.00	331,411,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	302,604,900.00	331,411,800.00
1330	Төсвийн захирагчдаас	70,803,540.00	00.00
133003	Хөрөнгийн	70,803,540.00	00.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,376,096.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,376,096.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	792,463,058.54	819,451,493.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	792,463,058.54	818,251,493.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	757,443,412.54	788,319,515.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	188,331,800.00	198,493,900.00
210101	Үндсэн цалин	176,943,800.00	198,493,900.00
210104	Урамшуулал	11,388,000.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,716,600.00	23,874,400.00
210201	Тэтгэврийн даатгал	12,988,619.00	15,913,201.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,944,156.00	1,989,149.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,555,323.00	1,681,912.00
210204	Ажилгүйдлийн даатгал	384,411.00	390,012.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,844,091.00	3,900,126.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,378,516.00	29,027,700.00
210301	Гэрэл, цахилгаан	3,045,216.00	3,045,300.00
210302	Түлш, халаалт	20,476,300.00	25,982,400.00
210303	Цэвэр, бохир ус	857,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,180,733.00	28,956,584.00
210401	Бичиг хэрэг	3,572,468.00	3,016,775.00
210402	Тээвэр, шатахуун	16,232,395.00	24,223,934.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,209,170.00	905,700.00
210404	Ном, хэвлэл	340,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	826,700.00	810,175.00
2105	Нормативт зардал	77,850.00	282,450.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	77,850.00	282,450.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	677,070.00	12,146,866.00
210602	Тавилга	75,000.00	00.00
210604	Урсгал засвар	602,070.00	12,146,866.00
2107	Томилолт, зочны зардал	7,822,600.00	5,675,000.00
210702	Дотоод албан томилолт	7,822,600.00	5,675,000.00

Бууцагаан сумын ЗДТГ 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	45,264,556.00	88,609,019.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	44,396,056.00	84,958,019.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	342,900.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	201,600.00	27,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	60,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	3,564,000.00
210807	Газрын төлбөр	74,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	446,993,687.54	401,253,596.69
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,697,470.00	4,078,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	238,900.00	8,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	437,057,317.54	397,166,096.69
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,019,646.00	29,931,978.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	4,340,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	4,340,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	33,715,196.00	1,800,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1,376,096.00	00.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	21,456,800.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,882,300.00	1,800,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,304,450.00	23,791,978.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,304,450.00	23,791,978.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	1,200,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	1,200,000.00
223001	Бусад хөрөнгө	00.00	1,200,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-307,031,592.54	-249,504,344.69
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	431,450,191.13
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	885,999.23
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	00.00	430,564,191.90
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-431,450,191.13
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-307,031,592.54	-680,954,535.82

1.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	366,489,894.00	486,943,730.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	16,825,413.00	21,675,930.00
120	Нийтлэг татварын бус орлого	16,825,413.00	21,675,930.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	16,825,413.00	21,675,930.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,825,413.00	21,675,930.00

Бууцагаан сумын ЗДТГ 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	349,664,481.00	465,267,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	45,683,485.00	133,856,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	45,683,485.00	133,856,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	302,604,900.00	331,411,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	302,604,900.00	331,411,800.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,376,096.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,376,096.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	366,489,894.00	486,943,730.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	366,489,894.00	486,943,730.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	331,470,248.00	461,351,752.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	188,331,800.00	191,922,684.00
210101	Үндсэн цалин	176,943,800.00	161,942,484.00
210102	Нэмэгдэл	00.00	29,980,200.00
210105	Гэрээт ажлын хөлс	11,388,000.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,716,600.00	22,187,243.00
210201	Тэтгэврийн даатгал	12,988,619.00	15,127,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,944,156.00	1,774,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,555,323.00	1,359,289.00
210204	Ажилгүйдлийн даатгал	384,411.00	268,648.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,844,091.00	3,658,106.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,521,916.00	28,122,579.00
210301	Гэрэл, цахилгаан	3,045,216.00	3,045,300.00
210302	Түлш, халаалт	20,476,300.00	25,077,279.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,400.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,842,200.00	22,061,400.00
210401	Бичиг хэрэг	3,007,900.00	2,851,300.00
210402	Тээвэр, шатахуун	14,715,400.00	16,603,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,377,800.00	965,700.00
210404	Ном, хэвлэл	291,400.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,449,700.00	1,641,000.00
2105	Нормативт зардал	00.00	159,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	159,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	970,700.00	3,189,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	3,000,000.00
210602	Тавилга	780,000.00	00.00
210604	Урсгал засвар	190,700.00	189,000.00
2107	Томилолт, зочны зардал	7,822,600.00	5,675,000.00
210702	Дотоод албан томилолт	7,822,600.00	5,675,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	57,840,542.00	181,834,946.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	56,845,342.00	178,183,946.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	00.00

Бууцагаан сумын ЗДТГ 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210803	Даатгалын үйлчилгээ	400,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	215,200.00	27,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	40,000.00	60,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	3,564,000.00
210807	Газрын төлбөр	90,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,423,890.00	6,199,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,899,000.00	6,099,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	524,890.00	100,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,019,646.00	25,591,978.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	33,715,196.00	1,800,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1,376,096.00	00.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	21,456,800.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,882,300.00	1,800,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,304,450.00	23,791,978.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,304,450.00	23,791,978.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

1.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2017 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл	502,400,904.00	110,689,256.00	3,409,271,416.43	00.00	4,022,361,576.43
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	502,400,904.00	110,689,256.00	3,409,271,416.43	00.00	4,022,361,576.43
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-307,031,592.54	00.00	-307,031,592.54
D01	2017 оны 17-р сарын 31-нээрх үлдэгдэл	502,400,904.00	110,689,256.00	3,102,239,823.89	00.00	3,715,329,983.89
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	12,268,308.00	00.00	12,268,308.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	502,400,904.00	110,689,256.00	3,114,508,131.89	00.00	3,727,598,291.89
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	340,256,931.28	00.00	00.00	340,256,931.28
D08	Тайлант үеийн үр дүн	18,000,000.00	00.00	-680,954,535.82	00.00	-662,954,535.82

Бууцагаан сумын ЗДТГ 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	520,400,904.00	450,946,187.28	2,433,553,596.07	00.00	3,404,900,687.35
-----	---------------------------------------	----------------	----------------	------------------	-------	------------------

1.18.Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	322,971,700.00	302,895,822.00	348,311,000.00	342,276,280.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	322,971,700.00	302,895,822.00	348,311,000.00	342,276,280.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	320,268,500.00	301,514,822.00	296,570,400.00	290,535,680.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	191,533,700.00	190,167,752.00	193,919,600.00	191,922,684.00
210101	Үндсэн цалин	182,412,800.00	182,179,693.00	163,939,400.00	161,942,484.00
210102	Нэмэгдэл	00.00	00.00	29,980,200.00	29,980,200.00
210105	Гэрээт ажлын хөлс	9,120,900.00	7,988,059.00	00.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,068,700.00	21,068,700.00	23,270,400.00	22,187,243.00
210201	Тэтгэврийн даатгал	13,408,249.00	13,408,249.00	15,706,400.00	15,127,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,532,136.00	1,532,136.00	1,891,000.00	1,774,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,915,337.00	1,915,337.00	1,512,800.00	1,359,289.00
210204	Ажилгүйдлийн даатгал	383,068.00	383,068.00	378,200.00	229,901.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,829,910.00	3,829,910.00	3,782,000.00	3,696,853.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,633,000.00	40,780,050.00	29,027,700.00	28,122,579.00
210301	Гэрэл, цахилгаан	3,313,000.00	2,678,450.00	3,045,300.00	3,045,300.00
210302	Түлш, халаалт	38,020,000.00	36,900,000.00	25,982,400.00	25,077,279.00
210303	Цэвэр, бохир ус	1,300,000.00	1,201,600.00	00.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	27,833,100.00	19,197,320.00	22,088,600.00	22,061,400.00
210401	Бичиг хэрэг	2,600,000.00	1,666,780.00	2,854,200.00	2,851,300.00
210402	Тээвэр, шатахуун	22,983,100.00	15,902,600.00	16,603,400.00	16,603,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,050,000.00	1,498,920.00	990,000.00	965,700.00
210404	Ном, хэвлэл	200,000.00	129,020.00	00.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	00.00	1,641,000.00	1,641,000.00
2105	Нормативт зардал	600,000.00	300,000.00	159,900.00	159,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	600,000.00	300,000.00	159,900.00	159,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,400,000.00	20,950,000.00	3,189,000.00	3,189,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	00.00	3,000,000.00	3,000,000.00
210602	Тавилга	19,500,000.00	19,500,000.00	00.00	00.00

Бууцагаан сумын ЗДТГ 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210604	Урсгал засвар	1,900,000.00	1,450,000.00	189,000.00	189,000.00
2107	Томилолт, зочны зардал	7,200,000.00	4,320,000.00	5,675,800.00	5,675,000.00
210702	Дотоод албан томилолт	7,200,000.00	4,320,000.00	5,675,800.00	5,675,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж				
		1,000,000.00	379,000.00	13,040,400.00	11,018,874.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,000,000.00	379,000.00	9,389,400.00	7,367,874.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	00.00	27,000.00	27,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	00.00	60,000.00	60,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	00.00	3,564,000.00	3,564,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7000000.00	4352000.00	6199000.00	6199000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,500,000.00	4,352,000.00	6,000,000.00	6,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	00.00	199,000.00	199,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2703200.00	1321000.00	51740600.00	51740600.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	00.00	49,940,600.00	49,940,600.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	00.00	49,940,600.00	49,940,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,703,200.00	1,321,000.00	1,800,000.00	1,800,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,703,200.00	1,321,000.00	00.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	00.00	1,800,000.00	1,800,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	322,971,700.00	302,895,822.00	348,311,800.00	342,277,080.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	304,899,900.00	284,754,022.00	00.00	00.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	304,899,900.00	284,754,022.00	00.00	00.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	15,071,800.00	15,071,800.00	331,411,800.00	330,386,348.00
132001	Орон нутгийн төсвөөс	15,071,800.00	15,071,800.00	331,411,800.00	330,386,348.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3,000,000.00	3,070,000.00	16,900,000.00	11,890,732.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,000,000.00	3,070,000.00	16,900,000.00	11,890,732.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	23.00	23.00	23.00	22.00
620001	Удирдах ажилтан	09.00	09.00	09.00	09.00
620002	Гүйцэтгэх ажилтан	12.00	12.00	10.00	09.00
620003	Үйлчлэх ажилтан	02.00	02.00	02.00	02.00
620004	Гэрээт ажилтан	00.00	00.00	02.00	02.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	23.00	23.00	23.00	22.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	08.00	08.00	07.00	06.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	07.00	07.00	06.00	06.00

Бууцагаан сумын ЗДТГ 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

650010	Гэрээт ажилтан	00.00	00.00	02.00	02.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	08.00	08.00	08.00	08.00